



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРААС ЗОХИОН БАЙГУУЛСАН ЭВЕНТИЙН ҮР ДҮН

2024 онд зохион байгуулсан 7 эвент арга хэмжээний нэгтгэл

Улаанбаатар хот
2024



Судалгаа хийх хэрэгцээ шаардлага

- Орон нутаг дахь эвентийг үзэх гадаад, дотоодын оролцогчид, үзэгчдийн тоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа ч эвент үзэгчдийн сэтгэл ханамжийг илтгэх судалгаа хийгдэхгүй байгаа нь зорилтот зах зээлээ татахгүй байх, жуулчид ирэхгүй байх, эвент нь жуулчдын оролцоог хангадаггүй зэрэг сөрөг үр дагавартай. Аялал жуулчлалын салбарт эвент зохион байгуулах нь зорин очих газруудын дүр төрхийг бий болгох, бусад зорих газруудаас ялгаатай бүтээгдэхүүнийг жуулчны зах зээлд байршуулан, өрсөлдөх давуу талыг бий болгодог. Энэхүү судалгааны ажлыг хийх дараах 2 үндсэн шалтгаантай. Үүнд:
 - 2023-2025 онуудыг МУ-ын засгийн газраас “Монголд Зочлох жил” болгон зарласантай холбогдуулан 6 ажлын хэсэг байгуулсны дотор эвент аялал жуулчлалыг хөгжүүлэх бие даасан хэсэг байгуулагдаж, аймаг, нийслэлийг брэнд эвенттэй болгохоор төлөвлөсөн бөгөөд бид Улаанбаатар хотын ойролцоо зохион байгуулагдаж буй эвент арга хэмжээний цар хүрээг тодорхойлох
 - Жуулчид татахын тулд судалгаа сайн хийх шаардлагатай бөгөөд эвентийн эдийн засгийн үр нөлөө, сэтгэл ханамжийг судлан тогтоох нь хамгийн чухал байв.
 - Судалгааг олон нийтийн цахим сүлжээгээр болон биечлэн авч судалгааны үр дүнг нэгтгэв. Судалгааны үр дүнг үнэлэхдээ дотоод, гадаадын жуулчдын сэтгэл ханамжийг судлан бүтээгдэхүүн үйлчилгээнд үнэлэлт, дүгнэлт өгөх үндсэн зорилтоо 100% биелүүлэв.




Эвентийн судалгааны үр дүнгийн боловсруулалтыг хийхдээ дараах бичиг баримтыг эх сурвалж болгов



ҮНДЭСЛЭСЭН БИЧИГ БАРИМТУУД



Афим Монголиа ТББ, ХХААХҮЯ, БОАЖЯ,
Дэлхийн банк - EDP "МУ-ын аялал
жуулчлалын эвентийн стратеги
төлөвлөгөө, бүтээгдэхүүн, хөгжлийн дүн
шинжилгээ, зөвлөмж"



ОЕСД Эдийн засгийн
хамтын ажиллагаа,
хөгжлийн байгууллага "АЖ
эрчимжүүлэх эвент"



Дэлхийн Эдийн засгийн
форум
"АЖ хөгжлийн индекс"



Канадын Калгарийн их сургуулийн
профессор Доналд Гетц "Эвент
аялал жуулчлалын
бүтээгдэхүүнүүдийг тодорхойлох нь"



ҮНДЭСЛЭСЭН БИЧИГ БАРИМТУУД

- Asia-Pacific Economic Cooperation, Introduction to Risk Management in Tourism-Instructor's Guide, 2018
- Azoev G.L.Sumarokova E.V (2020) Benchmarking of Market capacity assessment methods and their application to digital products
- Chaiwat Baimai, Jose Luis Daniel (2009) "Market Potential for Tourism in Emerging Markets"
- Consumer potential of households, its differentiation and dynamics in the new economy: evidence from Russia, Advances in Social Science, Education and Humanities Research, volume 240, 2018
- Donald Getz, "Event tourism: Definition, evolution, and research", TourismManagement 29 (2008)
- Emet GÜREL, SWOT Analysis: A Theoretical Review, 2017, Journal of International Social Research 10(51):994-1006
- Estimating the economic impacts of festivals and events: a research guide, 2017
- Gordon Shaw, M. Saayman, A. Saayman, Identifying risks facing the South African tourism industry, 2012
- Institute of Risk Management, A Risk Practitioners Guide to ISO 31000: 2018
- Market capacity assessment for educational service, Galina A.Kalugina,2020
- Morgan Westcott and Wendy Anderson, Eds, Introduction to Tourism and Hospitality in BC – 2nd Edition, 2021
- OECD (2017), "Major events as catalysts for tourism", *OECD Tourism Papers*, 2017/02, OECD Publishing, Paris
- Risk management – Risk assessment techniques, ISO 31010:2009
- Risk Management Guidelines, ISO 31000:2018, 2018
- Risk management-Vocabulary ISO Guide 73:2009
- "Strategy development using TOWS matrix for international project risk management based on prioritization of risk categories". Rahul Vishwanath Dandage and others. 22 March 2019 . "International Journal of Managing Projects in Business". ISSN: 1753-8378.
- Surya Prakash, Gunjan Soni, Ajay Pal Singh Rathore, Mitigation strategies for risk management and sustainability in supply chain, 2015
- The impact of 9/11 and other terrible global events on tourism in the U.S. and Hawaii
- World Economic Forum, The Travel and Tourism Competitiveness Report 2019
- Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд, Түүвэр судалгааны үр дүн Монголбанк, 2019


МОНГОЛ УЛСЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТҮҮДИЙН СУДАЛГАА

Эвентүүдийн зохиогдох хугацаа

High season	Middle season-1	Off season	Middle season-2
HS /6,7,8-р сарууд/	MS-1 /5,9,10-р сарууд/	OS /12,1,2-р сарууд/	MS-2 /3,4,11-р сарууд/
52	18	17	13

Эвент зохион байгуулагчдийн төрөл

БОАЖА, АЖХТ, НЗДТГ, НАЖГ	Орон нутгийн захиргаа /ЗДТГ, БОАЖГ/	ТББ, Холбоод, ОУ-ын байгууллагууд	Жуулчны бааз, амралтын газар	Тур оператор компани	Нутгийн иргэд, байгууллага
8	46	19	14	9	4




Аль болох эвентүүдийг бүх улиралд тархаан зохион байгуулдаг

Монгол улсын засгийн газраас жуулчдын
тоог нэмэгдүүлэх стратегийн зорилтын
хүрээнд бид бүхэн судалгаа хийв



MONGOLIA
ALWAYS MOVING




**Жуулчдын тоон өсөлтөд эвентийн зохион байгуулалт
хамгийн чухал**

МОНГОЛ УЛСЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАГДДАГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЭВЕНТҮҮД



Аялал жуулчлалын чиглэлээр нийт 120 гаруй эвентээс Нийслэлийн аялал жуулчлалын газрын зохион байгуулдаг **18% орчим эвент байна.**


ЖУУЛЧДЫГ ТАТАХ ТАТАЛЦЛЫН БҮС, ЖУУЛЧИН ХҮЛЭЭЖ АВАХ БОЛОМЖ



Хамгийн их таталцлын бүсэд эвентийг зохион байгуулж жуулчин урсгалаас олох эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх бодлого баримталж байна.




ЭВЕНТИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БҮС НУТГААР



18	Улаанбаатарын бүс
15	Баруун бүс
28	Хангайн бүс
27	Төвийн бүс
12	Зүүн бүс
100	



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРААС ЗОХИОН БАЙГУУЛДАГ ЭВЕНТИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦООЛОЛ, СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ СУДАЛГААНЫ ҮР ДҮН



Гадаад, дотоодын жуулчин, зочид, төлөөлөгчид 173.000 + хүн 7 удаагийн арга хэмжээнд оролцов.

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРААС ЗОХИОН БАЙГУУЛДАГ ЭВЕНТИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦООЛОЛ, СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ СУДАЛГААНЫ ҮР ДҮН



2024 он



Дотоодын
үзэгчдийн тоо

168.000

МЯНГА

ЖДҮ, Худалдаа эрхлэгчдийн
тоо

470

ЖУУЛЧДАД ҮЙЛЧИЛДЭГ

ТУР ОПЕРАТОР КОМПАНИ

100 орчим тур оператор

Хоол ундаагаар үйлчлэдэг аж ахуй
нэгж

288

Нийслэлтэй хамтрагч
байгууллага

50+

Хамтран ажилласан
байгууллагын тоо

171+



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРААС ЗОХИОН БАЙГУУЛДАГ ЭВЕНТИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦООЛОЛ, СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ СУДАЛГААНЫ ҮР ДҮН



2024 он



Гадаадын
жуулчдын тоо

5911

МЯНГА

Эвентэд очихын өмнөх
төсөөллийн судалгаанд
хамрагдсан иргэдийн тоо

256

Судалгаанд
хамрагдсан гадаад
иргэдийн тоо

502

Судалгаанд
хамрагдсан дотоодын
иргэдийн тоо

1497

Хоол хүнсний
үйлчилгээ эрхлэгчдийн
тоо

288



Худалдаа үйлчилгээ
эрхлэгчдийн тоо

407





Эвентүүдийн судалгааны үр дүн

Гадаад жуулчдын судалгааны үр дүн (Тоймлон түүвэрлэв)



“БҮРГЭДИЙН БАЯР”



ДЭЛХИЙН БӨӨГИЙН
ФЕСТИВАЛЬ



“ТАЛЫН САЛХИ” МОТО
ФЕСТИВАЛЬ



“ДЭЭЛТЭЙ МОНГОЛ”



“ДАНШИГ НААДАМ-
ХҮРЭЭ ЦАМ”



“UB FOOD 2024”



Эвентүүдийн судалгааны үр дүн



Гадаад жуулчдын судалгааны үр дүн (Нийтлэг асуултуудыг түүвэрлэв)



Солонгосын 7 хоног



Солонгосын 7 хоног





Эвентүүдийн судалгааны үр дүн

Гадаад жуулчдын судалгааны үр дүн (Тоймлон түүвэрлэв)



“БҮРГЭДИЙН БАЯР”

Эвентэд хүрэлцэн ирсэн хүмүүсийн 42% нь “Бүргэдийн баяр 2024”-ийн талаарх мэдээллийг Фейсбүүк хуудаснаас авсан байна. Энэ нь Монголчууд ихэвчлэн тухайн мэдээллийн платформыг ашиглдагийг илэрхийлж байгаа юм.

- “Бүргэдийн баяр”-т ирсэн аялагчдын сэтгэл ханамжийн талаар судалгаа авахад хүмүүсийн дийлэнх хамгийн өндөр буюу 75.9% нь сэтгэл ханамж өндөр, сайн байгаа гэсэн бөгөөд зохион байгуулсан өдрийн цаг агаар, арга хэмжээний төлөвлөлт, соёл урлагийн хөтөлбөр, бүргэд болон холбогдох анчин ноход, морьтон баатруудийн үзүүлбэр зэрэг нь сонирхол татаж тааламжтай сэтгэгдлийг түрүүлж чадсан эвент болсон гэдгийг үүнээс харж болно.
- “Бүргэдийн баяр”-т хүрэлцэн ирсэн хүмүүсийн дийлэнх хувь болох 74% нь Улаанбаатар хотоос, 23% нь бусад орон нутгаас, гадны улс орнуудаас 3% нь зорин ирсэн бөгөөд үүнээс дүгнэвэл тус баяр нь дотоодын аялагчдын сонирхолд нийцсэн, казак үндэстний өвөрмөц соёл, ахуй уламжлал зэргийг монголын ард түмэнд сурталчлан таниулж чадахуйц эвент болж өндөрлөсөн гэж үзэж болно.
- 20 улсын 43 гадаад жуулчдаас бүргэдийн баярын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнг авахад, “Бүргэдийн баяр-2024” эвентэд Ази жуулчдаас илүү Европ, Америк тивийн жуулчид илүү давамгайл ирсэн бөгөөд эдгээр хүмүүсийн ихэнх хувь нь найз нөхөдтэйгөө цагийг хөгжилтэй өнгөрөөх зорилготой ирсэн байна.
- Эвентийн талаарх судалгааг жуулчин бүрээс авч, тулгарсан асуудлуудын талаар асуухад гадаад хэл дээрх мэдээлэл, эх сурвалж олдоогүй, хангалтгүй мөн эвентийн тасалбар, бусад үйлчилгээг авахад гагцхүү банкны аппликейшн ашиглах боломжтой байсан зэрэг хүндрэл гарсан гэж бидэнд хэлж байсан.





Эвентүүдийн судалгааны үр дүн

Гадаад жуулчдын судалгааны үр дүн (Тоймлон түүвэрлэв)



ДЭЛХИЙН БӨӨГИЙН
ФЕСТИВАЛЬ

1. Олон улсын болон орон нутгаас оролцож буй бөөгийн ёс заншил, онцлогтой танилцах боломжтойгоор зохион байгуулжээ.
2. Хоол, хүнс, бэлэг дурсгал, хүүхдэд зориулсан тусгай хөтөлбөр, жуулчдад зориулсан энтертайнмент арга хэмжээ, вэб сайтын мэдээлэл сайн
3. Морьт эргүүл, машинт эргүүл, гал команд, онцгой байдал, түргэн тусламж, цагдаа зэрэг Тусгай зориулалтын баг хамт олны оролцоо сайн
4. Зогсоолын нэгдсэн цэгээс цахилгаан тээврийн хэрэгслээр хүмүүст үйлчилсэн. Урт маршрутын тээвэрлэлт сайн.
5. 27 улсын Тэнгэр шүтлэгтэн бөө нар хүрэлцэн ирсэн.
6. Зах зээлд 1,5 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтыг бий болгосн байна.



“ТАЛЫН САЛХИ” МОТО ФЕСТИВАЛЬ

Эвентийн судалгааны үр дүн

- Талын салхи" фестиваль нь мото спорт сонирхдог хүн бүрийн наадам бөгөөд нийт оролцогч сонирхогчдын тоог 2023 онтой харьцуулахад 35 хувиар өсөж, 1900 орчим мотоцикл сонирхогчид парадад оролцсон нь тус наадмын түүхэнд хамгийн их мото сонирхогчдыг нэг дор цуглуулж чадсан арга хэмжээ болсон юм.
- Энэ удаагийн мото наадамд Монгол улсаас 30 мотоклубын 1500 гаруй мотоцикл сонирхогчид болон гадаад улс орнуудаас БНХАУ-ын 70, ОХУ-ын 200, БНСУ-ын 10, Малайз, Вьетнам, АНУ зэрэг улсын мото сонирхогчид оролцлоо.
- Мөн анх Мотоциклын ангиллын чопперийн төрлийн мото спорт сонирхогчид түлхүү оролцдог байсан бол өдгөө Чоппер, Кросс, 4 дугуйт мотоцикл, Крузер, Стрийт, ATV, UTV, Мопед зэрэг олон төрлөөр хүрээгээ тэлж, оролцогчдын тоо ч жил ирэх тусам өссөн байна.
- 1200 машин, 10000 орчим дотоодын оролцогчид , 64 асар 20 орчим бэлэг дурсгал, хоол үйлчилгээ 20 орчим үйлчилгээ эрхлэгч уг эвентэд оролцов.





“ТАЛЫН САЛХИ” МОТО ФЕСТИВАЛЬ

Эвентийн судалгааны үр дүн

- Мото фестивалийн оролцоо нь тухайн арга хэмжээний нэр хүнд, байршил, цар хүрээ зэргээс хамаарч өөр өөр байж болох ч эдийн засагт эерэг нөлөө үзүүлдэг. Жишээ нь MotoGP наадам нь ялангуяа аялал жуулчлал болон бусад зардлаар дамжуулан эдийн засагт ихээхэн үр өгөөж өгдөг. Тухайлбал, 2022 онд болсон MotoGP цуврал дэлхийн хэмжээнд 2.4 сая гаруй үзэгчийг татсан ба эдийн засагт эерэг нөлөөлөл бий болгож чадсан байна.
- Уг эвент зах зээлд 2,1 тэрбум төгрөгийн эргэлт оруулсан.

Хамгийн их Таалагдсан
зүйл





Эвентүүдийн судалгааны үр дүн

Гадаад жуулчдын судалгааны үр дүн (Тоймлон түүвэрлэв)



“ДЭЭЛТЭЙ МОНГОЛ”

- Монголчуудын уламжлалт өв соёл, үндэсний хувцасны язгуур хэв шинж, угсаатны дээл хувцас, эд хэрэглэл, соёлын биет бус өвийг сурталчлах замаар Нийслэл Улаанбаатар хотыг Олон Улсад сурталчлах, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгоход чиглэсэн уг наадам энэ жил 18 дахь жилдээ зохион байгуулж байна.
- “Дээлтэй Монгол” наадамд Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн төлөөллөөс гадна БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөлөн буйр аймгийн “Хөрөнгө оруулагчдын холбоо”, Баруун үзэмчин хошуу, Ордос аймгийн Монголчууд, Монгол туургатны утга зохиол, өв соёлын “Дорнын гэгээ аялгуу” нэгдсэн холбоо, Шинжаан уйгурын өөртөө засах орны Торгууд, Өөлд, Цахар, Хошуут, Захчин, Урианхай, Халх үндэстэн ястнуудын төлөөлөл бүхий Ойрад Монголчууд, ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улсын Буриад Монголчууд, ОХУ-ын Бүгд найрамдах Халимаг улсын Элстэйн холбоо гэх мэт гадаад 200 гаруй улсын оролцогчид оролцсон нь уг арга хэмжээний хамгийн чухал үр дүн байв.
- БНХАУ, ОХУ -аас Монгол туургатнууд Монгол баяр наадамд зорин ирж оролцсон ба 2,5 саяас -4.0 сая төгрөгийг төлөвлөж ирсэн байна.
- Жуулчны сэтгэгдэл: Үндэстэн, угсаатны олон янзын дээл хувцас, соёлыг нэг дор мэдрэх боломжийг олгосон гэж сэтгэгдэл өндөр байгаагаа онцолсон байна.





Эвентүүдийн судалгааны үр дүн

Гадаад жуулчдын судалгааны үр дүн (Тоймлон түүвэрлэв)



“ДЭЭЛТЭЙ МОНГОЛ”

- Нийт судалгаанд оролцогчдын 29,4% нь хотын аялалд хамрагдаж байгаад энэхүү эвентэд санамсаргүй байдлаар оролцжээ.
- Дээл, гутал, малгай, унжлага, зүүлт, хэт хутга, толгойн гоёл, бүс, нүүр будалт, үс засалт тэргүүтэнд зардал гардаг байна. Хамгийн багадаа өөрсдөө урлаж хийсэн дээл хувцас тэргүүтэнд 300.000 мянган төгрөгний зардал гаргадаг байна.
- Гадаад жуулчдын 78,8 % нь арга хэмжээний хоорондын зохицол маш сайн гэж үнэлсэн байна.
- Жуулчдын хувьд мэдээллийн хүртээмжийг сайжруулан гадаад хэл дээр мэдээлэл авах боломжийг нэмэгдүүлэх хүсэлтийг жуулчид өгч байв.
- Судалгааны түүврээс үзэхэд уг эвент арга хэмжээнд оролцогчид 3.500.000.000-4.000.000.000 тэрбум төгрөгийг эдийн засгийн эргэлтэд оруулдаг байна. Зорин ирсэн Монгол туургатан иргэд 680.000.000-720.000.000 сая төгрөгийг зарж уг эвент арга хэмжээнд оролцсон байна.
- Нийслэлийн АЖГ -аас зохион байгуулсан эвент арга хэмжээ анх зохион байгуулж байсан үеэс 10 дахин их оролцогч, үзэгчдийг татдаг эвент арга хэмжээ болон өргөжсөн байна.
- Нэг өдрийн арга хэмжээнд оролцогч жуулчдын 8,5% -ийг хамруулан судалгааны таамаглалыг гаргав.



“ДАНШИГ НААДАМ-ХҮРЭЭ ЦАМ”



- Даншиг наадам, хүрээ цам шашны их цэнгүүн, соёл, уламжлалын арга хэмжээг Монгол орны өнцөг булан бүрээс 90.0000 хүн үзэж сонирхов.
- Мөн БНХАУ, ОХУ, БНСУ, Япон, Вьетнам, АНУ, Европын улсуудын зочин гийчид 2000 гаруй хүн, дипломат төлөөлөгчид, олон улсын байгууллагын албаны хүмүүс, шашин судлаачид зэрэг гадаад орнуудын төлөөлөл өргөн бүрэлдэхүүнтэй оролцон наадав.
- Судалгааны баг наадамчин олны төлөөллөөс санамсаргүй түүврийн аргаар 400 хүний сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг нэгтгэн гаргалаа. Судалгаанд гадаадын жуулчин, зочдын төлөөлөл 130 хүн, дотоодын 270 хүн хамрагдаж наадмын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг үнэлэн цаашид анхаарах санал, зөвлөмж хүргүүллээ
- Баяр наадмын өдрүүдэд 19600 орчим тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцсоноос гадна хотын тээврийн газраас 10 том оврын автобус төв цэнгэлдэх хүрээлэн, МУБИС гэсэн 2 чиглэлээс өдрийн туршид олон нийтэд үйлчиллээ.
- Хүй долоон хутагт наадамчдад үйлчлэх хоол хүнс, худалдаа, гар урлал, шоу үзүүлбэр, тоглоом наадгай зэрэг олон чиглэлийн үйл ажиллагаа аюул, эрсдэлгүй зохион байгуулагдсан нь иргэдээс өндөр үнэлгээ авав.
- Эвентийг Нийслэлийн засаг даргын тамгын газар, НАЖГ, Бурхан шашны төв Гандан тэгчлэн хийд, Нийслэлийн дүүргүүд, Хүчний байгууллагууд /цагдаа, онцгой байдал/, эрүүл мэнд, хот тохижилтын газар зэрэг олон байгууллага эмх журамтай, өргөн хүрээг хамарсан байдлаар амжилттай зохион байгуулсан гэж үзэж байна.



“UB FOOD FESTIVAL”

Эвентийн судалгааны үр дүн



- Монгол үндэсний хоол, хүнс болон олон үндэсний хоолны соёлыг гадаад, дотоодын иргэд, жуулчдад сурталчлан таниулах зорилго бүхий “UB FOOD FESTIVAL” арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд 10 дахь жилдээ зохион байгуулагдлаа.
- UB FOOD FESTIVAL-д ресторан, зоогийн газар, кофе шоп зэрэг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний 40 гаруй байгууллага Монгол үндэсний болон Европ, Япон, Солонгос, Мексик, Чех, Энэтхэг хоол болон зууш, кофе, амттанаар 3 өдрийн турш үйлчиллээ. Мөн шилдэг тогооч нарын онцгой хоолны үзүүлбэр, сонирхолтой урлаг, соёлын энтертайнмент амьд хөгжмийн болон бусад урлагийн тоглолт хөтөлбөртэй, тэмцээн уралдаантай, оролцогчдыг хамруулсан хөгжөөнт тэмцээнтэйгээр зохион байгуулав.
- Уг эвент арга хэмжээнд 25.000-27.000 мянган дотоодын иргэд оролцож, 20 гаруй орны тухайлбал Англи, АНУ, Тайвань, Филиппин, Чех, ОХУ, Австрали, Казахстан, Тажикстан, БНСУ, Япон, Лаос, Вьетнам, Франц, Итали, Испани, Голланд зэрэг улсын 1800 гаруй жуулчид оролцов.
- Нийслэлийн Аялал жуулчлалын газраас 400 гаруй гадаад, дотоодын иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа, оролцогч 40 аж ахуйн нэгжээс зохион байгуулалтын болон эдийн засгийн орлого, ашгийн судалгааг авч нэгтгэлээ.
- Уг арга хэмжээ нь нийслэл хотын төдийгүй зорин ирж буй зочдын сонирхлыг татсан арга хэмжээ болж оролцогч, үзэгчдийн тоо өмнөх жилийнхээс 2 дахин нэмэгдсэн байна. Уг эвент арга хэмжээний үеэр 650.000 гаруй сая төгрөгийн хоол, хүнс, бараа бүтээгдэхүүн зарж борлуулсан байна.




“Солонгосын 7 хоног” Эвентийн судалгааны үр дүн

- Энэхүү эвент арга хэмжээнд оролцсон байгууллага аж ахуйн нэгжүүд 65.000.000 төгрөгний борлуулалт хийсэн
- БНСУ-ын Хойд Гёнсан муж болон Жоннам мужаас нутгийн өөрөө удирдах байгууллагын төлөөлөл болох 25 компани хүрэлцэн ирсэн бөгөөд Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй Хоол хүнс, Гоо сайханы үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллага оролцож үйлчилгээ үзүүлсэн.
- Энэ үеэр Солонгосоос хүрэлцэн ирсэн “Юн Мён Хва” Солонгос үндэсний бүжгийн хамтлаг, "НУМУРИ" амьд хөгжмийн хамтлаг уран бүтээлээ толилуулах бөгөөд Солонгос ардын урлагийн тоглолт, Электрик үндэсний хөгжмийн тоглолт, Жинду бөмбөрт бүжиг, Таэквондогийн үзүүлбэр гэх мэт олон сонирхолтой тоглолт, үзүүлбэрүүд тоглож 2 өдрийн арга хэмжээнд 2000 гаруй хүнд үйлчилгээ үзүүлсэн байна.



Нийт жуулчдын хүрэлцэн ирсэн тээврийн хэрэгсэлийн сонголт



Railway Port 3.1%

Road port 11%

Airport 85.9%

*Source: Судлаачдын боловсруулсан хувилбар


Жуулчдын Монгол орны сонгох болсон шалтгаан харьцуулалт (1998-2024)



№	Reasons to Visit Mongolia	1998	2002	2004	2005	2012	2018	2024 эвент
1	Stunning Landscapes	66 %	69 %	53 %	78 %	61 %	65 %	57%
2	Traditional Mongolian Culture	51 %	46 %	35 %	60 %	43 %	47 %	45%
3	Adventure Travel	24 %	26 %	19 %	32 %	12 %	23 %	12%
4	Wildlife Experiences	31 %	25 %	20 %	23 %	9 %	22 %	21%
5	History of Mongolia and Genghis Khan	27 %	21 %	16 %	21 %	11 %	19 %	14%
6	Other	12 %	12 %	4 %	1 %	12 %	8 %	8%
7	Special Interests	10 %	9 %	5 %	-	6 %	6 %	5%
8	Festivals and Events	-	-	-	-	-	5.5 %	10%
9	Hunting and Fishing	2 %	1 %	1 %	4 %	2 %	2 %	-




Нийслэлийн аялал жуулчлалын газраас зохион байгуулсан эвентэд оролцсон тээврийн хэрэгслийн судалгаа



**Гадаад, дотоодын жуулчин, зочид, төлөөлөгчид 30.000 гаруй
тээврийн хэрэгсэл ашиглан эвент арга хэмжээнд оролцов.**

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРААС ЗОХИОН БАЙГУУЛДАГ ЭВЕНТИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦООЛОЛ, СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ СУДАЛГААНЫ ҮР ДҮН



**Эвент арга хэмжээнүүд нь нийслэлийн эдийн засагт
16.036.000.000 тэрбум төгрөг шуудаар оруулсан байна.**

MONGOLIA

· ALWAYS · MOVING ·

THANK YOU
for your attention